

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2023/106/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2023 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор Ц.Төмөрсүх

Утас: 9805-8805, Цахим хаяг: lightanddelightaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 253

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Баян-Уул сумын  
Эрүүл мэндийн төвийн  
Дарга Б.ДЭЛГЭРМАА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

#### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу үнэлсэн нөлөө бүхий эрсдэлтэй удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал үйл явдал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хангалттай зохистой гэж үзлээ.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020354

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>127,548,502.95</u></b>	<b><u>19,342,622.13</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	2,116,798.85	8,963,179.33
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	2,116,798.85	8,963,179.33
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	2,116,798.85	8,963,179.33
31211	Төрийн сангийн харилцах	2,116,798.85	8,963,179.33
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	74,112,980.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	74,112,980.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	51,318,724.10	10,379,442.80
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	30,392,204.10	39,000.00
35110	Тусгай зориулалттай материал	134,200.00	39,000.00
35130	Эм боох материал	30,258,004.10	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	480,000.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	20,446,520.00	10,340,442.80
35410	Бичиг хэргийн материал	102,800.00	-
35420	Аж ахуйн материал	15,071,890.00	5,136,250.00
35440	Түлш, шатах тослох материал	4,075,250.00	3,113,342.80
35460	Хүнсний материал	1,139,600.00	2,026,850.00
35470	Бусад хангамжийн материал	56,980.00	64,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>584,126,650.23</u></b>	<b><u>649,271,108.22</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	584,126,650.23	649,271,108.22
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	550,126,650.23	615,271,108.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	281,346,319.43	281,346,319.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(35,454,822.12)	(47,273,096.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,530,600.00	62,530,600.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,493,100.00)	(22,866,016.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	236,851,060.52	296,170,136.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	(67,813,413.58)	(65,631,803.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	94,897,015.41	101,865,795.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,405,816.49)	(13,892,563.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	115,982,207.00	115,982,207.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(79,313,399.94)	(92,960,470.43)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	34,000,000.00	34,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	34,000,000.00	34,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>711,675,153.18</u></b>	<b><u>668,613,730.35</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>711,675,153.18</u></b>	<b><u>668,613,730.35</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	711,675,153.18	668,613,730.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	542,615,532.19	542,615,532.19
51101	Өмч: - төрийн	542,615,532.19	542,615,532.19
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	164,239,924.91	125,998,198.16
51210	Өмнөх үеийн үр дүн	(44,575,703.22)	169,059,620.99
51220	Тайлант үеийн үр дүн	208,815,628.13	(43,061,422.83)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,819,696.08	-
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>711,675,153.18</u></b>	<b><u>668,613,730.35</u></b>

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,467,736,162.08</b>	<b>824,977,194.85</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>951,781,462.08</b>	<b>96,332,034.85</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	304,449,412.08	96,332,034.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	304,449,412.08	96,332,034.85
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	14,810,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	304,449,412.08	81,522,034.85
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	7,945,650.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	7,945,650.00	-
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	639,386,400.00	-
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	639,386,400.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>515,954,700.00</b>	<b>728,645,160.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	23,262,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	21,262,300.00	-
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	2,000,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	60,832,400.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,112,400.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,720,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	34,400,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	34,400,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	431,860,000.00	694,245,160.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	431,860,000.00	694,245,160.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,225,253,867.16</b>	<b>868,038,617.68</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,225,253,867.16</b>	<b>868,038,617.68</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,115,217,556.16	867,905,693.88
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	467,065,929.20	479,946,495.00
210101	Үндсэн цалин	248,737,806.00	310,316,478.00
210102	Нэмэгдэл	135,505,323.00	102,952,492.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,442,681.00	6,230,253.00
210104	Урамшуулал	76,380,119.20	60,447,272.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,149,852.55	60,231,184.07
210201	Тэтгэврийн даатгал	45,117,119.55	41,755,865.18
210202	Тэтгэмжийн даатгал	4,079,367.00	4,809,751.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,263,694.00	3,837,721.45
210204	Ажилгүйдлийн даатгал	789,970.00	893,441.50
210205	Эрүүл мэндийн даатгал	7,899,702.00	8,934,404.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,558,931.00	29,142,076.20
210301	Гэрэл, цахилгаан	5,455,931.00	5,468,576.20
210302	Түлш, халаалт	20,983,000.00	23,673,500.00
210304	Байрны түрээс	3,120,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	51,949,410.00	51,125,657.20
210401	Бичиг хэрэг	6,011,800.00	5,221,600.00
210402	Тээвэр, шатахуун	16,231,650.00	14,559,907.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,266,800.00	1,268,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,678,080.00	2,214,320.00

**Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,761,080.00	12,789,740.00
210408	Бараа материал акталсны зардал	-	15,071,890.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>430,068,113.86</b>	<b>124,143,430.83</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	401,914,254.56	97,890,289.38
210502	Хоол, хүнс	18,799,855.30	22,920,141.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,354,004.00	3,333,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,529,500.00</b>	<b>19,800,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,489,500.00	-
210604	Урсгал засвар	5,040,000.00	19,800,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,780,000.00</b>	<b>4,563,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,780,000.00	4,563,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>389,218.00</b>	<b>634,069.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,950.00	59,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	519,200.00
210807	Газрын төлбөр	21,600.00	21,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45,668.00	769.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>60,726,601.55</b>	<b>98,319,481.58</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,393,800.00	21,777,310.54
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,332,801.55	76,542,171.04
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>110,036,311.00</b>	<b>132,923.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>109,857,200.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	109,857,200.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>179,111.00</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	179,111.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>132,923.80</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	132,923.80
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>242,482,294.92</b>	<b>(43,061,422.83)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>33,666,666.79</b>	<b>-</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	33,666,666.79	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(33,666,666.79)</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>208,815,628.13</b>	<b>(43,061,422.83)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,089,173,770.00</b>	<b>817,568,140.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>647,332,050.00</b>	<b>88,922,980.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>-</b>	<b>88,922,980.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>-</b>	<b>88,922,980.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	88,922,980.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>7,945,650.00</b>	<b>-</b>
122001	Хандив тусламж /дотоод/	7,945,650.00	-
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>639,386,400.00</b>	<b>-</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	639,386,400.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>441,841,720.00</b>	<b>728,645,160.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>23,262,300.00</b>	<b>-</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	21,262,300.00	-

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	2,000,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	60,832,400.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,112,400.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,720,000.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	34,400,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	34,400,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	357,747,020.00	694,245,160.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	357,747,020.00	694,245,160.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,087,056,971.15</b>	<b>810,721,759.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,087,056,971.15</b>	<b>810,721,759.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>988,859,860.15</b>	<b>810,588,835.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	467,065,929.20	479,946,495.00
210101	Үндсэн цалин	248,737,806.00	310,316,478.00
210102	Нэмэгдэл	135,505,323.00	102,952,492.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,442,681.00	6,230,253.00
210104	Урамшуулал	76,380,119.20	60,447,272.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,149,852.55	60,231,184.07
210201	Тэтгэврийн даатгал	45,117,119.55	41,755,865.18
210202	Тэтгэмжийн даатгал	4,079,367.00	4,809,751.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,263,694.00	3,837,721.45
210204	Ажилгүйдлийн даатгал	789,970.00	893,441.50
210205	Эрүүл мэндийн даатгал	7,899,702.00	8,934,404.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,426,689.00	29,267,076.20
210301	Гэрэл, цахилгаан	5,323,689.00	5,468,576.20
210302	Түлш, халаалт	20,983,000.00	23,673,500.00
210303	Цэвэр, бохир ус	-	125,000.00
210304	Байрны түрээс	3,120,000.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	61,782,677.80	45,860,770.00
210401	Бичиг хэрэг	9,314,900.00	2,735,200.00
210402	Тээвэр, шатахуун	19,870,100.00	13,598,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,266,800.00	1,321,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,999,902.80	2,023,770.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,330,975.00	26,182,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	194,376,156.60	80,957,091.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	169,299,706.10	48,385,500.00
210502	Хоол, хүнс	18,782,446.50	29,558,591.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,294,004.00	3,013,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	160,889,337.00	91,936,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	151,733,337.00	66,938,900.00
210602	Тавилга	-	19,998,000.00
210604	Урсгал засвар	9,156,000.00	5,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,780,000.00	4,563,000.00
210702	Дотоод албан томилолт	1,780,000.00	4,563,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	389,218.00	993,219.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	48,950.00	59,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	519,200.00

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	21,600.00	21,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	45,668.00	769.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	359,150.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,000,000.00</b>	<b>16,833,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	16,833,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>98,197,111.00</b>	<b>132,923.80</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>98,018,000.00</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	98,018,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>179,111.00</b>	<b>-</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	179,111.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>-</b>	<b>132,923.80</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	132,923.80
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,116,798.85</b>	<b>6,846,380.48</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>2,116,798.85</b>	<b>6,846,380.48</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>2,116,798.85</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>8,963,179.33</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	542,615,532.19	6,433,694.83	(46,189,701.97)	502,859,525.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,613,998.75	1,613,998.75
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>542,615,532.19</b>	<b>6,433,694.83</b>	<b>(44,575,703.22)</b>	<b>504,473,523.80</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(1,613,998.75)	-	(1,613,998.75)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	208,815,628.13	208,815,628.13
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>542,615,532.19</b>	<b>4,819,696.08</b>	<b>164,239,924.91</b>	<b>711,675,153.18</b>
D01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>542,615,532.19</b>	<b>4,819,696.08</b>	<b>164,239,924.91</b>	<b>711,675,153.18</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	4,819,696.08	4,819,696.08
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>542,615,532.19</b>	<b>4,819,696.08</b>	<b>169,059,620.99</b>	<b>716,494,849.26</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(4,819,696.08)	-	(4,819,696.08)
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(43,061,422.83)	(43,061,422.83)
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>542,615,532.19</b>	<b>-</b>	<b>125,998,198.16</b>	<b>668,613,730.35</b>

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	750,605,300.00	810,588,835.72
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	750,605,300.00	810,588,835.72
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	750,605,300.00	810,588,835.72
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	481,357,000.00	479,946,495.00
210101	Үндсэн цалин	277,449,900.00	310,316,478.00
210102	Нэмэгдэл	157,950,800.00	102,952,492.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,338,800.00	6,230,253.00
210104	Урамшуулал	38,617,500.00	60,447,272.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,170,300.00	60,231,184.07
210201	Тэтгэврийн даатгал	40,915,300.00	41,755,865.18
210202	Тэтгэмжийн даатгал	4,814,100.00	4,809,751.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,851,200.00	3,837,721.45
210204	Ажилгүйдлийн даатгал	962,800.00	893,441.50
210205	Эрүүл мэндийн даатгал	9,626,900.00	8,934,404.87
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,399,200.00	29,267,076.20
210301	Гэрэл, цахилгаан	7,200,000.00	5,468,576.20
210302	Түлш, халаалт	22,000,000.00	23,673,500.00
210303	Цэвэр, бохир ус	199,200.00	125,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	59,494,400.00	45,860,770.00
210401	Бичиг хэрэг	3,150,000.00	2,735,200.00
210402	Тээвэр, шатахуун	23,000,000.00	13,598,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,344,800.00	1,321,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	2,023,770.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,999,600.00	26,182,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	44,980,800.00	80,957,091.45
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,794,400.00	51,080,100.00
210502	Хоол, хүнс	16,686,000.00	26,863,991.45
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,500,400.00	3,013,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	52,019,500.00	91,936,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,019,500.00	66,938,900.00
210602	Тавилга	-	19,998,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,000,000.00	4,563,000.00
210702	Дотоод албан томилолт	6,000,000.00	4,563,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,184,100.00	993,219.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	200,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	59,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,600.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,183,300.00	519,200.00
210807	Газрын төлбөр	21,600.00	21,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	240,000.00	769.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	359,150.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,000,000.00	16,833,100.00

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,000,000.00	16,833,100.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	750,606,100.00	817,435,216.20
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	34,400,000.00	34,267,076.20
122005	Орон нутгийн төсвөөс	34,400,000.00	34,267,076.20
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	716,206,100.00	783,168,140.00
122001	Хандив тусламж /дотоод/	716,206,100.00	783,168,140.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	2,116,798.85
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	8,963,179.33

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төв нь Иргэдийн хүсэл хэрэгцээг хангахуйц, нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэхэд чиглэгдэнэ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль хүрээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ард иргэдэд хүргэн үйлчилж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43.1 сая төгрөгөөр буюу 6.1 хувиар буурсан байна.

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,116.8	8,963.2	6,846.4
Авлага	74,113.0	-	(74,113.0)
Бараа материал	51,318.7	10,379.4	(40,939.3)
Үндсэн хөрөнгө	584,126.7	649,271.1	65,144.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>711,675.2</b>	<b>668,613.7</b>	<b>(43,061.4)</b>
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	711,675.2	668,613.7	(43,061.4)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>711,675.2</b>	<b>668,613.7</b>	<b>(43,061.4)</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны авлага бүрэн барагдсан байна.

Тайлант онд бараа материал дансны үлдэгдэл 10.4 сая төгрөг болж, 40.9 сая төгрөгөөр буурсан нь зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 649.3 сая төгрөг болж 65.1 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь 143.5 сая төгрөгийн хөрөнгө орлогод бүртгэж, тайлант онд 52.2 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцож бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 668.6 сая төгрөг болж 43.1 сая төгрөгөөр буурсан нь тайланд хугацааны алдагдалтай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 716.2 сая, орон нутгийн төсвөөс 34.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 750.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг 750.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээс 716.2 сая төгрөг авахаас 694.2, урсгал үйл ажиллагааны санхүүжилтээс 34.4 сая төгрөг авахаас 34.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Мөн батлагдсан төсвөөс гадна дээд шатны байгууллагаас 14.8 сая төгрөг /Хүснэгт 2-т зарцуулалтыг харуулав/, эрүүл мэндийн даатгалын сангаас авах /Ковид19/ өмнөх оны авлага болох 74.1 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 810.6 сая төгрөг буюу 107.99 хувьтай байгаа нь өмнөх оны авлага төлөгдөж, төсвийн зарцуулах эрх нээлгэн зарцуулсантай холбоотой байна.

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				<i>/Мянган төгрөгөөр/</i>	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Ахмад сувилал	3600.0	3600.0	0	100
2	Ковид сувилал	3300.0	3300.0	0	100
3	Хүүхдийн сувилал	600.0	600.0	0	100
4	ДЭМБ	6000.0	6000.0	0	100
5	Томуу вакцин	760.0	760.0	0	100
6	Сүрьеэ сорьц	350.0	350.0	0	100
7	Монголын эмч мэргэжилтний холбоо	200.0	200.0	0	100
	Нийт	14810.0	14810.0		100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайланд хугацаанд нэмэлт дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Лайт энд Дилайт Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Нурболат, аудитор Ц.Төмөрсүх, хяналтыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 2 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 860.9 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 12.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор санхүүгийн сахилга батыг мөрдөж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах бодлогыг баримтлан ажилласан байна.

Тухайн байгууллагын батлагдсан орон тоон дээр дэд дарга, орлогчийн албан тушаалын ажилтан байхгүй байгаа бөгөөд авто тээврийн хэрэгсэл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ буюу төрийн хэмнэлтийн хуулийн 6 дугаар зүйлд заасан авто тээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагатай байгууллага байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус байгууллага нь 2022 онд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 744.0 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтад нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

“Сүхжин” ХХК-иас 15.9 сая, Улзын буян ХХК -аас 8.1 сая, нийт 24.0 сая төгрөгийн худалдан авалтад цахим төлбөрийн баримт гаргуулан аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, сангийн сайдын 2017 оны 347 тушаалаар батлагдсан өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэж заасныг зөрчсөн, хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага хүргүүлсэн.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 3 албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт 100 хувь байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	71,516.5	3	71,516.5	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>71,516.5</b>	<b>3</b>	<b>71,516.5</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдах авах гэрээ, тайланг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцэж байх эсэхийг үзэх.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулсан. Үүнд: 2022 оны 12-р сарын үндсэн хөрөнгүүдийн элэгдлийн зардал бодоогүй байсныг тооцуулан бүртгэл, тайланд тусгуулсан.

Аудитаар нийт 10.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.

#### 5.1 Албан шаардлага

1. Бараа материалын дансанд бүртгэлтэй 10.3 сая төгрөгийн хөрөнгөд тооллого хийгээгүй, баталгаажуулж дүнг санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1-д “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Баян-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
2022 оны 12-р сарын үндсэн хөрөнгүүдийн элэгдлийн зардал тооцоогүй.	1	7,122.1	1	7,122.1			1	7,122.1				
Дүн	1	7,122.1	1	7,122.1	-	-	1	7,122.1	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жилийн эцсээр зөвхөн үндсэн хөрөнгийг тоолсон бөгөөд бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй.	1	10,379.4			1	10,379.4						
Дүн	1	10,379.4			1	10,379.4	-	-	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд орлогын гүйлгээний дүнг мэдүүлээгүй.	1	744,051.3					1	744,051.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн төлбөрт цахим төлбөрийн баримт шивүүлээгүй	1	24,045.1					1	24,045.1
Дүн	2	768,096.4	0	-	2	768,096.4	0	-